



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар сарын 1-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 360
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ,
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 25.1, 30.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн захиргааны удирдлагын бүтцийг дараахь байдлаар тогтоосугай:

1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;

1.2. Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч;

1.3. Нийслэлийн Засаг даргын цахим хөгжил, хууль, эрх зүй, төрийн үйлчилгээний асуудал хариуцсан орлогч;

1.4. Нийслэлийн Засаг даргын нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч;

1.5. Нийслэлийн Засаг даргын авто замын түгжрэлийг бууруулах болон зам, тээврийн асуудал хариуцсан орлогч;

1.6. Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч;

1.7. Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогч;

1.8. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

1.9. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;

1.10. Нийслэлийн Ерөнхий архитектор.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

- 2.1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвтэй);
- 2.2. Санхүү, төрийн сангийн хэлтэс (Өрийн удирдлагын тасагтай);
- 2.3. Хууль, эрх зүйн хэлтэс;
- 2.4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс;
- 2.5. Нийгмийн бодлогын хэлтэс;
- 2.6. Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс (Хөрөнгө оруулалтын тасагтай);
- 2.7. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс;
- 2.8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
- 2.9. Хүний нөөцийн удирдлагын хэлтэс (Хүний нөөцийн хөгжлийн төвтэй);
- 2.10. Цэргийн штаб.

3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дараахь байдлаар тогтоосугай:

- 3.1. Захиргаа, санхүүгийн хэлтэс;
- 3.2. Хотын инженерийн байгууламжийн хэлтэс;
- 3.3. Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хэлтэс;
- 3.4. Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс;
- 3.5. Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтэс;
- 3.6. Хяналт, үнэлгээний хэлтэс.

4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 139, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 60, дүүргийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт 68, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт 59, Багануур, Налайх дүүрэгт 39, Багахангай дүүрэгт 25 (нормативаар ажиллах орон тоо орохгүй) байхаар тогтоосугай.

5. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараахь агентлаг ажиллуулахаар тогтоосугай:

- 5.1. Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар;
- 5.2. Архивын газар;
- 5.3. Аялал жуулчлалын газар;

- 5.4. Байгаль орчны газар (Зуслангийн товчоотой);
- 5.5. Бизнес инновац хөгжлийн газар;
- 5.6. Дотоод аудитын алба;
- 5.7. Замын хөгжлийн газар;
- 5.8. Биеийн тамир, спортын газар;
- 5.9. Боловсролын газар;
- 5.10. Газар зохион байгуулалтын алба;
- 5.11. Хот байгуулалт, хөгжлийн газар;
- 5.12. Орон сууцны бодлогын газар;
- 5.13. Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар;
- 5.14. Нийтийн тээврийн газар;
- 5.15. Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар;
- 5.16. Өмчийн харилцааны газар;
- 5.17. Соёл, урлагийн газар;
- 5.18. Худалдан авах ажиллагааны газар;
- 5.19. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- 5.20. Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар;
- 5.21. Эрүүл мэндийн газар;
- 5.22. Хотын стандарт, хяналтын газар;
- 5.23. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
- 5.24. Мал эмнэлгийн газар;
- 5.25. Мэргэжлийн хяналтын газар;
- 5.26. Нийгмийн даатгалын газар;
- 5.27. Нийгмийн халамжийн газар;
- 5.28. Нийтлэг үйлчилгээний газар;

5.29. Улсын бүртгэлийн газар;

5.30. Онцгой байдлын газар (нөөцийн албатай);

5.31. Статистикийн газар;

5.32. Татварын газар;

5.33. Хөдөлмөр эрхлэлтийн газар;

5.34. Цагдаагийн удирдах газар;

5.35. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт даалгасугай:

6.1. Нийслэлийн замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дэргэд байгуулж ажиллуулах;

6.2. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, алдагдалтай ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн алдагдлыг бууруулах, үр өгөөжтэй ажиллуулахад гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах ажлыг зохион байгуулах;

6.3. Нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эх үүсвэрийг бий болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэт цаас гаргах, концесс олгох ажлыг зохион байгуулах.

7. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт зөвшөөрсүгэй.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай” Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

9. Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.НЯМДОРЖ